



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэсийн буян ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/007/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Өмнөговь аймаг	Утас: 70533539 Цахим хаяг: <a href="mailto:usukhbayarts@audit.gov.mn">usukhbayarts@audit.gov.mn</a>
2026 он	Аудитын менежер: Т.Хонгорзул
	Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:khongorzult@audit.gov.mn">khongorzult@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Г.Шижирболд
	Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:umnugovi@audit.gov.mn">umnugovi@audit.gov.mn</a>
	Азуре хүлэг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр
	Утас: 70110090 Цахим хаяг: <a href="mailto:audit@azure.mn">audit@azure.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 324  
тавай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

"ЭРДЭНЭСИЙН БУЯН" ОНӨААТҮГ-  
ЫН ЗАХИРАЛ Л.АМАРТҮВШИН  
ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Эрдэнэсийн буян" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, татварын өр төлбөрийн үлдэгдэл нь татварын тодорхойлолтын дүнгээс зөрүүтэй, цалингийн тооцооллыг ажилчдын бүртгэлийг хянаж, баталгаажуулдаггүй, анхан шатны баримт бүрдэл хангалтгүй зэрэг 9,117.3 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 19 дүгээр зүйлийн 19.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, 20.2.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2, 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.6, 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй "Нутгийн дэм" хөтөлбөрт хамрагдаж, байгууллагын албан хаагчдад нийт 61,671.3 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

4626050486

112/Булган хирэл/2026/007/СТА-ОНӨҮГ

### **Аудитын гол асуудал**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжаар 3,196.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, 3,196.4 мянган төгрөгөөр бүртгэсэн, Хүрмэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр 3,435.4 төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус үйлдвэрийн газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгагдсан асуудал нь хамаарахгүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	365,126,012.95	319,575,312.99
1.1.2	Дансны авлага	5,947,119.92	8,403,019.33
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.6	Бараа материал	51,504,706.17	57,958,448.18
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>422,577,839.04</b>	<b>385,936,780.50</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,590,370,053.34	3,526,483,842.78
1.2.2	Биет бус хөрөнгө	10,782,833.17	10,572,833.17
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3,601,152,886.51</b>	<b>3,537,056,675.95</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,023,730,725.55</b>	<b>3,922,993,456.45</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	6,124,548.84	6,917,118.63
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,722,384.68	1,722,384.68
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>7,846,933.52</b>	<b>8,639,503.31</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Бусад урт хугацаат өглөг	3,274,904,713.44	3,264,586,611.24
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>3,274,904,713.44</b>	<b>3,264,586,611.24</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>3,282,751,646.96</b>	<b>3,273,226,114.55</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	516,282,358.81	516,282,358.81
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	86,652,471.18	86,652,471.18
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	138,044,248.60	46,832,511.91
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>740,979,078.59</b>	<b>649,767,341.90</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,023,730,725.55</b>	<b>3,992,993,456.45</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	488,856,080.14	435,149,397.19
2	Борлуулалтын өртөг	200,390,514.30	447,612,570.97
<b>3</b>	<b>Нийт ашиг</b>	<b>325,384,357.26</b>	<b>(12,463,173.78)</b>
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	2,091,085.92	877,576.75
6	Ногдол ашгийн орлого	-	61,671,270.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	34,827,705.50	168,066,046.74
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	231,931,260.87	309,275,698.71
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>93,453,096.39</b>	<b>(91,123,979.00)</b>
19	Орлогын татварын зардал	9,577,651.88	87,757.69
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>83,875,444.51</b>	<b>(91,211,736.69)</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>83,875,444.51</b>	<b>(91,211,736.69)</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	516,282,358.81	86,652,471.18	138,044,248.60	740,979,078.59
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(91,211,736.69)	(91,211,736.69)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	516,282,358.81	86,652,471.18	46,832,511.91	649,767,341.90

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>569,910,185.08</b>	<b>712,418,938.51</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	569,910,185.08	712,418,938.51
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>483,927,370.33</b>	<b>757,969,638.47</b>
	Ажиллагчдад төлсөн	187,484,130.00	298,514,598.50
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	5,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	17,191,358.51	35,807,887.52
	Ашиглалтын зардалд төлсөн	9,743,146.00	17,367,923.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	43,853,771.01	84,328,662.54
	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
	Бусад мөнгөн зарлага	3,690,934.00	7,613,396.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>85,982,814.75</b>	<b>(45,550,699.96)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хүлээн авсан ноогдол ашиг	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	<b>56,895,810.52</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	56,895,810.52
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
4.1	Валютын ханшийн зөрүү	-	-
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	85,982,814.75	(45,550,699.96)
<b>5.1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>279,143,198.20</b>	<b>365,126,012.95</b>
<b>5.2</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>365,126,012.95</b>	<b>319,575,312.99</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Тайлант оны ( 2025 )			
		2025 оны Батлагдсан төлөвлөгөө	2025 оны Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	<b>Нийт борлуулалтын орлого</b>	<b>656,005.7</b>	<b>665,764.3</b>	<b>9,758.6</b>	<b>101.5</b>
	<b>Үйл ажиллагааны борлуулалтын орлого</b>	<b>562,682.6</b>	<b>589,760.9</b>	<b>27,078.2</b>	<b>104.8</b>
1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих / Дулаан борлуулсны орлого	397,016.6	397,448.8	432.2	100.1
2	Ус хангамж, ариутгах татуурга	43,866.0	43,866.0	-	100.0
3	Хот тохижилт, үйлчилгээ	120,000.0	120,000.0	-	100.0
4	Бусад орлого үйл ажиллагааны	1,800.0	28,446.0	26,646.0	1,580.3
5	Банкны хүүний орлого	1,585.9	877.6	(708.3)	55.3
6	Бусад орлого (Нутгийн дэм)	79,200.0	61,671.3	(17,528.7)	77.9
7	Бусад орлого ( Хойшлогдсон хөрөнгийн орлого)	12,537.1	13,454.6	917.4	107.3
	<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>655,405.5</b>	<b>756,888.3</b>	<b>101,482.7</b>	<b>115.5</b>
1	Түүхий эдийн зардал	50,000.0	47,866.9	(2,133.1)	95.7
2	Ажилчдын цалин	395,223.0	413,386.0	18,163.0	104.6
3	НДШ,ЭМД	57,307.3	57,248.4	(58.9)	99.9
4	Элэгдлийн зардал	37,806.7	126,625.0	88,818.3	334.9
5	Хойшлогдсон хөрөнгийн элэгдэл	12,537.1	13,454.6	917.4	107.3
6	Албан томилот	1,890.0	2,020.0	130.0	106.9
7	Шуудан холбоо	2,016.0	1,547.1	(468.9)	76.7
8	Банкны шимтгэл	205.9	205.9	-	100.0
9	Цахилгаан	32,970.5	37,353.3	4,382.8	113.3
10	Шатахуун	18,083.0	17,367.9	(715.1)	96.0
11	Хөдөлмөр хамгаалал	15,108.0	10,787.7	(4,320.3)	71.4
12	Бичиг хэрэг	901.0	800.8	(100.2)	88.9
13	Сэлбэг	5,357.0	4,571.3	(785.6)	85.3
14	Хангамжийн материал	15,500.0	14,120.3	(1,379.7)	91.1
15	Албан татвар төлбөр хураамж	1,500.0	1,473.2	(26.8)	98.2
16	Бусад зардал	9,000.0	8,060.0	(940.0)	89.6
	<b>Нийт зардлын дүн</b>	<b>655,405.5</b>	<b>756,888.3</b>	<b>101,482.7</b>	<b>115.5</b>
	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал</b>	<b>600.2</b>	<b>(91,124.0)</b>	<b>(91,724.1)</b>	<b>(15,183.50)</b>
	Орлогын татварын зардал	60.0	87.8	27.7	146.2
	Татвар дараах ашиг/алдагдал	540.1	(91,211.7)	(91,751.9)	(16,886.8)
	<b>Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал</b>	<b>540.1</b>	<b>(91,211.7)</b>	<b>(91,751.9)</b>	<b>(16,886.8)</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 100.9 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад 100.9 сая төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн ажилчдын нийгмийн даатгалд төлсөн 100.1 сая төгрөгийн зардлын дүнг ангилал буруу тайлагнасан;
- Цалингийн тооцоололд нийгмийн даатгалын хувь хэмжээг буруу оруулж тооцоолсноор 0.8 сая төгрөгийн зардлыг буруу тайлагнасан.

Аудитаар нийт 9.1 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 3.0 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6.1 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1.3 сая төгрөгөөр их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

Хаан банкны харилцах дансны 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ажил гүйлгээгээр нягтлан бодогчийн хувийн данс руу "сургалтын төлбөрийн дэмжлэг олгов" гэх утгатай 3.0 сая төгрөг шилжүүлсэн нь сургалтын гэрээ болон бусад анхан шатны баримтаар нотлогдохгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.2.1 "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 4.2.6 "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", 15 дугаар зүйлийн 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомж зөрчиж олгосон сургалтын төлбөрийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дансны авлага, өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацааны эцсээр татварын байгууллагаас авах 4.3 сая төгрөгийн авлага, бусад байгууллагад төлөх 1.7 сая төгрөгийн өглөгүүд нь ямар тайлант хугацаанд үүссэн тодорхойгүй, татварын тодорхойлолтоос зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Эрдэнэсийн буян ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг гаргахын өмнө өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, харилцагч тодорхойгүй төлбөр тооцооны үлдэгдлийг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

2. Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажилчдын гарт олгох цалин нь 10, 11, 12 сарын цалингийн тооцооны хүснэгтийн дүнгээс зөрүүтэй, ажилчдын илүү цаг болон ирсэн, явсан цагийн бүртгэлийг хянаж, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно, Эрдэнэсийн буян ОНӨААТҮГ-ын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.2 "Ажилтан ажилдаа өглөө ирсэн. завсарласан, ажлаас орой тарсан цагаа бүртгүүлнэ. Ажлын цагийн ашиглалтын бүртгэлийг сар бүр нэгтгэн мэдээлж байна. Энэ нь цалин хөлс олгох баримт болно." гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаг бүртгэл, цалингийн тооцоололд хяналт тавьж, сар бүрийн бүртгэл тооцоог эрх бүхий албан тушаалтнууд баталгаажуулж, анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй Орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнгөн гүйлгээний тайлангийн ажилчдын нийгмийн даатгалд төлсөн зардлын дүнг буруу тайлагнасан байна.	1	100,094.3	-	-	1	100,094.3	1	100,094.3	-	-	-	-
2	Цалингийн тооцоололд нийгмийн даатгалын хувь хэмжээг буруу оруулж тооцоолсноор зардлыг буруу тайлагнасан байна.	1	875.3	-	-	1	875.3	1	875.3	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>100,969.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>100,969.6</b>	<b>2</b>	<b>100,969.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Хаан банкны харилцах дансны 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ажил гүйлгээгээр нягтлан бодогчийн хувийн данс руу "сургалтын төлбөрийн дэмжлэг олгов" гэх утгатай 3,000.00 мянган төгрөг шилжүүлсэн нь сургалтын гэрээ болон бусад анхан шатны баримтаар нотлогдохгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй байна.	1	3,000.0	1	3,000.0	-	-	-	-	-	-	-	-	-
2	Тайлант хугацааны эцсээр татварын байгууллагаас авах 4,394.9 мянган төгрөгийн авлага, бусад байгууллагад төлөх 1,722.3 мянган төгрөгийн өглөгүүд нь ямар тайлант хугацаанд үүссэн тодорхойгүй, татварын тодорхойлолтоос зөрүүтэй байна.	1	6,117.2	-	-	-	-	1	6,117.2	-	-	-	-	-
3	Ажилчдын гарт олгох цалин нь 10, 11, 12 сарын цалингийн тооцооны хүснэгтийн дүнгээс зөрүүтэй, ажилчдын илүү цаг болон ирсэн, явсан цагийн	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-

Эрдэнэсийн буян ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

бүртгэлийг хянаж, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй.														
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>9,117.2</b>	<b>1</b>	<b>3,000.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>6,117.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт</b>									
1	Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 170 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна. Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 191,634.1 мянган төгрөгийн 20 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	191,634.1	-	-	-	-	1	191,634.1
<b>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт</b>									
2	Өмнөговь аймгийн засагт даргаар батлуулсан бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллаагүй 91,211.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	1	91,211.7	-	-	-	-	1	91,211.7
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>282,845.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>282,845.8</b>